

**МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААН ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН
АХЛАХ СУРГУУЛЬД 2018-2019 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛД
СУРАЛЦАГЧ ЭЛСҮҮЛЭХ ЖУРАМ**

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 1.1. Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2002 оны 333 дугаар тушаалын хавсралт “Ерөнхий боловсролын сургуульд гүнзгийрүүлсэн болон мэргэжлийн сургалт зохион байгуулах үлгэрчилсэн журам”-ын 3.3 дахь заалт, шинжлэх ухаан технологийн их сургуулийн холбогдох журмууд, шинжлэх ухаан технологийн их сургуулийн ахлах сургуулийн (сургалтын) үйл ажиллагааг зохицуулах журмын 6.1, 6.2 дахь заалтыг тус тус баримлан ШУТИС-ийн ахлах сургуульд 2018-2019 оны хичээлийн жилд суралцагч элсүүлэхэд энэхүү журмыг мөрдөнө.
- 1.2. ШУТИС-ийн ахлах сургуульд элсэн суралцахаар хүсэлт гаргагч /”бүртгүүлэгч” гэх/, элсэлтийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах элсэлтийн комиссын үйл ажиллагаатай холбоотой харилцааг энэ журмаар зохицуулна.
- 1.3. Сургуулийн материаллаг бааз, анги кабинетын хүрэлцээ зэргээс хамааран шинээр элсэх суралцагсдын тоог Захирлын зөвлөлийн шийдвэрээр тогтооно.

ХОЁР. ЭЛСЭЛТИЙН КОМИССЫГ БАЙГУУЛАХ

- 2.1. ШУТИС-ийн ахлах сургуулийн элсэлтийн үйл ажиллагааг зохион байгуулах комиссын бүрэлдэхүүн, гишүүдийн ажил үүргийн хуваарийг ШУТИС-ийн Захирлын тушаалаар батална.
- 2.2. Элсэлтийн комисс нь энэхүү журмыг баримтлан бүртгүүлэгчийн материалыг шалгах, элсэлтийн шалгалтыг зохион байгуулах, өргөдөл гомдлыг барагдуулах, элсэлтийн явцад хяналт тавих болон элсэлттэй холбоотой бусад үйл ажиллагааг зохицуулна.

ГУРАВ. БҮРТГҮҮЛЭГЧИД ТАВИГДАХ ШААРДЛАГА

- 3.1. Суурь боловсролтой
- 3.2. Инженер техник, технологийн болон архитектур дизайн чиглэлээр суралцах сонирхолтой байх

ДӨРӨВ. ШУТИС-ИЙН АХЛАХ СУРГУУЛЬД БҮРТГҮҮЛЭГЧДИЙГ БҮРТГЭХ

- 4.1. ШУТИС-ийн ахлах сургуульд бүртгүүлэгчид 2018 оны 05 сарын 21-ны өдрөөс 2018 оны 06 сарын 08-ны өдрийн 09.00 -18.00 цагийн хооронд ШУТИС-ийн IV байр, ШУТИС-ийн ахлах сургуулийн сургалтын албаны өрөө 308 тоотод ирж бүртгүүлнэ.
- 4.2. Бүртгүүлэгч нь дараах материалыг бүрдүүлсэн байна.
 - 4.2.1. Төрсний гэрчилгээ
 - 4.2.2. Хоёр хувь цээж зураг (сүүлийн 6 сарын)
 - 4.2.3. Төрөлжсөн хичээлүүдийн олимпиадад орсон бол түүнд үзүүлсэн амжилтыг гэрчлэх баримт
 - 4.2.4. Бүртгүүлэхдээ эцэг эх, болон асран хамгаалагчийн төлөөлөлийг заавал дагуулж ирэх
 - 4.2.5. Бүртгэлийн хураамж -5000 төгрөг
- 4.3. Шаардлага хангасан бүртгүүлэгчид шалгалтын комиссоос бүртгэлийн хуудас олгоно.

ТАВ. СУРАЛЦАГЧ ЭЛСҮҮЛЭХ ШАЛГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ

- 5.1 Шалгалтын үндсэн зарчим
 - 5.1.1. Сурагчдын сэтгэх бодох чадварыг нээн илрүүлэх боломжтой байх
 - 5.1.2. Шалгалтын даалгавар, шалгуур нь түвшинд тохирсон, үнэн зөв, сурагчдад ойлгомжтой, бодитой үнэлэлт, дүгнэлт өгөх бололцоотой байх
 - 5.1.3. Шалгалт шударга, ил тод байх
 - 5.1.4. Шалгалтын авах хэлбэр нь тодорхой, нийтэд мэдээлэгдсэн байх

- 5.2. Шалгалтыг зохион байгуулах
 - 5.2.1. Шалгалтын хугацааг 14-21 хоногийн өмнө олон нийтэд зарлах
 - 5.2.2. Элсэгчдийн эцэг эх, асран хамгаалагчдаас оролцуулан хөндлөнгийн хяналт тавих
- 5.3. Шалгалтын дэг
 - 5.3.1. ШУТИС-ийн ахлах сургуулийн элсэлтийн шалгалтыг 2018 оны 06 сарын 09-ны өдөр зохион байгуулж авна. Үүнд: Бүх элсэгчдээс математикийн хичээлээр шалгалт авна. Харин архитектур дизайны бэлтгэл ангид орох хүсэлтэй сурагчдаас нэмэлтээр зургийн шалгалт авна.
 - 5.3.2. Шалгалтын сэдэв боловсруулах багийг томилох, нууцлалыг хадгалан ажиллах үүргийг шалгалтын комисс хариуцна.
 - 5.3.3. Шалгалтын сэдвийг суурь боловсролын хичээлүүдийн агуулгыг бүрэн багтаасан, 3 хувилбартайгаар боловсруулна.
 - 5.3.4. Шалгалтын сэдвийг шалгалт авах өдрийн 06.00 – 08.00 цагийн хооронд сонгон, шалгуулагчдын тоогоор хувилж олшруулан бэлтгэнэ.
 - 5.3.5. Шалгалт авах өдрийн 08.00- 09.00 цагийн хооронд комиссын гишүүд шалгуулагчдыг бүртгэлийн хуудастай тулган ангиудад хуваарилан оруулж ассистент багш болон хөндлөнгийн хянагчдыг томилно.
 - 5.3.6. Ассистент багш шалгалтын материалыг тарааж, шалгалтыг эхлүүлнэ.
 - 5.3.7. Шалгалтын хугацаа дуусмагц ассистент багш шалгуулагчийн материалыг шифрлэж шалгалтын материалыг хурааж авна.
 - 5.3.8. Шалгалтын үеийн үйл ажиллагааг ассистент багш протокол хөтлөн тэмдэглэсэн байна.
 - 5.3.9. Шалгалтын явцад шалгуулагчаас зөрчил гарвал шалгалтаас шууд чөлөөлнө.
- 5.4. Шалгалтын материал засах
 - 5.4.1. Шалгалт дууссаны дараа томилогдсон багш нар материалыг засаж дүнг шалгалтын хуудсанд засваргүйгээр тэмдэглэн баталгаажуулж шалгалтын комисст хүлээлгэн өгнө
 - 5.4.2. Шифрийг тайлж, онооны дарааллаар нь жагсаан шалгуулагчийн оноог шифрлэж сургуулийн website, болон мэдээллийн самбарт байрлуулан танилцуулна.

ЗУРГАА. СУРАЛЦАГЧ ЭЛСҮҮЛЭХ

- 6.1. ШУТИС-ийн ахлах сургуулийн элсэлтийн шалгалтанд тэнцсэн сурагчдын нэрсийг шалгалтын комисс шийдвэрлэн заасан хугацаанд нийтэд мэдээлнэ.
- 6.2. ШУТИС-ийн ахлах сургуулийн элсэлтийг зохион байгуулах комиссын зохион байгуулсан шалгалтын оноог үндэслэн суралцагч элсүүлнэ.
- 6.3. Суралцахыг хүсэгч нь 2017-2018 оны хичээлийн жилд төрөлжсөн хичээлүүдийн нийслэл, улсын олимпиадад 1-5-р байр, бүс, улс, олон улсын чанартай олимпиад, уралдаан тэмцээнд 1-10-р байр эзэлсэн бол энэ амжилтыг харгалзан үзэж шууд элсүүлнэ.
- 6.4. Элсэлттэй холбоотой аливаа маргааныг элсэлтийн комисс эцэслэн шийдвэрлэнэ.

ДОЛОО. ЭЛСЭГЧДИЙГ БҮРТГЭХ

- 7.1. Элсэлтийн комиссын шийдвэрээр шалгалтанд тэнцсэн элсэгчдийг 2018 оны 06 сарын 12-ны өдрөөс 2018 оны 06 сарын 15-ны өдрүүдэд ШУТИС-ийн ахлах сургуулийн хичээлийн байранд бүртгүүлэн суралцах эрхийн бичгээ авна. Элсэгч нь бүртгүүлэхээр ирэхдээ доорх материалыг бүрдүүлэн авч ирнэ. Үүнд:
 - 7.1.1. Сурагчийн хувийн хэрэг
 - 7.1.2. Суурь боловсролын гэрчилгээ /10-р ангийн дүнгийн тодорхойлолт/
 - 7.1.3. Төрсний гэрчилгээ
 - 7.1.4. Хоёр хувь цээж зураг (сүүлийн 6 сарын)
 - 7.1.5. Төрөлжсөн хичээлүүдийн олимпиадад орсон бол түүнд үзүүлсэн амжилтыг гэрчлэх баримт
 - 7.1.6. Бүртгүүлэхдээ эцэг эх, болон асран хамгаалагчийн төлөөлөлийг заавал дагуулж ирэх
- 7.2. Суралцах эрх авсан боловч заасан хугацаанд ирж бүртгүүлээгүй элсэгчдийг элсэхээс

татгалзсан гэж үзээд элсэх эрхийг хүчингүй болсонд тооцно.

- 7.3. Сурагчийн хувийн хэрэг болон, суурь боловсролын гэрчилгээний зөрчилтэй сурагчдыг элсүүлэхгүй болно.

НАЙМ. НЭМЭЛТ ЭЛСЭЛТ АВАХ

- 8.1. Нэмэлт элсэлтийн бүртгэл 2018 оны 08 сарын 20-24-ний өдрийн 09.00 -18.00 цагийн хооронд ШУТИС-ийн IV байр, Ахлах сургуулийн сургалтын албаны өрөө 308 тоот өрөөнд явагдана.
- 8.2. Бүртгүүлэгч ШУТИС-ийн ахлах сургуулийн нэмэлт элсэлтэнд бүртгүүлэхдээ тус журмын 4.2 дугаар зүйлд заасны дагуу материал бүрдүүлж бүртгүүлнэ.
- 8.3. Шаардлага хангасан бүртгүүлэгчид шалгалтын комиссоос нэмэлт элсэлтийн бүртгэлийн хуудас олгож, элсэлтийн шалгалтыг зохион байгуулж элсүүлнэ.
- 8.4. Нэмэлт элсэлтийн шалгалтыг 2018 оны 08 сарын 25-ны өдрийн 09.00 цагт тус журмын 5 дугаар зүйлд заасны дагуу зохион байгуулж авна.
- 8.5. Элсэлтийн шалгалтанд тэнцсэн бүртгүүлэгчийг тус журмын 6 дугаар зүйлд заасны дагуу элсүүлэн суралцуулна.